ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/140/СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Улаанбаатар хот<br>2021он | Дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: Т.Ган-Өлзий<br>Утас: 7052-2734<br>Цахим хаяг: ganulzii.b@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: У.Оюунтүлхүүр<br>Утас: 7052-3020<br>Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn<br><br>Аудитор: Ш.Нарантуяа<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Гэрэлт хөхийн тэнцвэр Аудит" ХХК<br>Утас: 9611-2118 Цахим хаяг: Gerelt.audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| НБББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |

## Агуулга

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан........5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан........7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан........9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан........11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан........12
3.Аудитын тайлан........15
3.1. Ерөнхий зүйл........15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй........15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт........16
3.4. Материаллаг байдал........16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд........16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт........17
3.7. Шилэн дансны мэдээлэл........18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт........18
3.9. Аудитын илрүүлэлт........18
Аудитын зөвлөмж:........17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд........19
4. Менежментийн захидал........19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт........20

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021. 02. 25 № 1-6/163

танай ______________-ны №______________-т

АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА Г.ӨЛЗИЙБҮРЭН ТАНАА

## Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

44002057

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **93,837,051.80** | **115,350,191.80** |
| **33** | **АВЛАГА** | 00.00 | 11,375,120.00 |
| **335** | **Бусад авлага** | 00.00 | 11,375,120.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 11,375,120.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 93,837,051.80 | 103,975,071.80 |
| **351** | **Түүхий эд материал** | 00.00 | 3,094,520.00 |
| 35130 | Эм боох материал | 00.00 | 3,094,520.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 93,837,051.80 | 100,880,551.80 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 5,390,967.00 | 6,227,167.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 87,775,084.80 | 93,053,302.80 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 431,000.00 | 431,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 00.00 | 248,932.00 |
| 35460 | Хүнсний материал | 240,000.00 | 920,150.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,091,540,981.85** | **1,244,373,694.17** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,091,540,981.85 | 1,244,373,694.17 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,055,540,981.85 | 1,208,373,694.17 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 885,820,823.92 | 1,079,974,711.92 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -27,659,165.04 | -82,977,495.12 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 50,600,000.00 | 50,600,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -33,147,222.21 | -36,580,555.53 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 331,042,438.27 | 323,953,784.27 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -168,441,131.02 | -205,651,636.90 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 57,431,983.54 | 59,293,883.54 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -40,106,745.61 | -45,116,202.01 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 6,172,145.92 | 71,049,349.92 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -6,172,145.92 | -6,172,145.92 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 36,000,000.00 | 36,000,000.00 |
| 39301 | Програм хангамж | 917,500.00 | 917,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -917,500.00 | -917,500.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 36,000,000.00 | 36,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,185,378,033.65** | **1,359,723,885.97** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **284,502.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 284,502.00 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 284,502.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 284,502.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,185,378,033.65** | **1,359,439,383.97** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,185,378,033.65 | 1,359,439,383.97 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 965,074,695.17 | 965,074,695.17 |
| 51101 | Өмч: - төрийн | 965,074,695.17 | 965,074,695.17 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -74,584,244.55 | 99,477,105.77 |

| | | | |
|---|---|---|---|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -74,584,244.55 | -74,584,244.55 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 174,061,350.32 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 294,887,583.03 | 294,887,583.03 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,185,378,033.65** | **1,359,723,885.97** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **487,094,650.00** | **694,663,131.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **74,806,010.00** | **263,052,492.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 74,806,010.00 | 263,052,492.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 74,806,010.00 | 263,052,492.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,300,000.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 65,506,010.00 | 263,052,492.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **118,986,740.00** | **95,035,039.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 293,301,900.00 | 336,575,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 80,142,340.00 | 66,755,440.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 51,232,340.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 23,000,000.00 | 3,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,910,000.00 | 63,755,440.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 38,844,400.00 | 28,279,599.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 38,844,400.00 | 28,279,599.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **483,978,364.32** | **520,412,160.68** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **483,978,364.32** | **520,412,160.68** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 480,514,591.32 | 518,214,907.68 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 145,925,337.00 | 171,213,800.00 |
| 210101 | Үндсэн цалин | 138,766,537.00 | 141,895,000.00 |
| 210102 | Нэмэгдэл | 7,158,800.00 | 29,318,800.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 17,962,454.00 | 23,113,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,962,931.00 | 16,265,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,412,601.00 | 1,712,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,127,599.00 | 1,369,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 267,938.00 | 342,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,191,385.00 | 3,424,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,185,000.00 | 26,796,328.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,477,278.00 | 3,497,642.00 |
| 210302 | Түлш, халаалт | 21,426,146.00 | 21,185,784.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,281,576.00 | 2,112,902.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,738,494.40 | 4,258,062.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,666,730.00 | 1,785,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,784,654.40 | 920,068.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,412,500.00 | 1,114,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 144,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 874,610.00 | 294,494.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,448,795.00 | 3,842,873.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,448,795.00 | 3,842,873.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,117,000.00 | 261,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,117,000.00 | 261,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 144,801,901.60 | 169,688,915.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 143,187,901.60 | 167,242,915.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 200,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 800,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 78,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 177,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,614,000.00 | 181,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 1,010,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 115,335,609.32 | 119,039,329.68 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 31,890,996.00 | 6,150,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,789,500.00 | 932,950.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 80,655,113.32 | 111,956,279.68 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3,463,773.00 | 2,197,253.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 950,000.00 | 943,420.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 950,000.00 | 943,420.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,513,773.00 | 1,253,833.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,513,773.00 | 1,253,833.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **3,116,285.68** | **174,250,970.32** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 3,507,010.22 | 189,620.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 180,000.22 | 00.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 3,327,010.00 | 189,620.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -3,507,010.22 | -189,620.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-390,724.54** | **174,061,350.32** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан
/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **421,988,640.00** | **431,610,639.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **9,700,000.00** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 9,700,000.00 | 00.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 9,700,000.00 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,700,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **412,288,640.00** | **431,610,639.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 293,301,900.00 | 336,575,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 80,142,340.00 | 66,755,440.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 51,232,340.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 23,000,000.00 | 3,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,910,000.00 | 63,755,440.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 38,844,400.00 | 28,279,599.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 38,844,400.00 | 28,279,599.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **411,741,440.00** | **427,748,739.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **411,741,440.00** | **427,748,739.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **408,277,667.00** | **413,,730,366.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 142,100,200.00 | 171,213,800.00 |
| 210101 | Үндсэн цалин | 134,941,400.00 | 141,895,000.00 |
| 210102 | Нэмэгдэл | 7,158,800.00 | 29,318,800.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 17,716,860.00 | 23,113,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,729,500.00 | 16,265,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,379,900.00 | 1,712,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,104,000.00 | 1,369,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 276,000.00 | 342,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,227,460.00 | 3,424,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,425,000.00 | 26,271,826.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,477,278.00 | 3,497,642.00 |
| 210302 | Түлш, халаалт | 21,426,146.00 | 21,185,784.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,521,576.00 | 1,588,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,416,300.00 | 5,954,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,641,830.00 | 2,000,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,326,360.00 | 1,200,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,307,500.00 | 1,114,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн | 00.00 | 144,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | устгал, ариутгал | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,140,610.00 | 1,496,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,415,295.00 | 3,572,873.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,415,295.00 | 3,572,873.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,117,000.00 | 261,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,117,000.00 | 261,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 153,832,162.00 | 172,844,317.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 152,218,162.00 | 170,398,317.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 200,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 800,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 78,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 177,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,614,000.00 | 181,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 1,010,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 37,254,850.00 | 10,497,950.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,933,350.00 | 9,465,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,321,500.00 | 1,032,950.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,463,773.00** | **13,572,373.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 950,000.00 | 943,420.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 950,000.00 | 943,420.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,513,773.00 | 12,628,953.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,513,773.00 | 12,628,953.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **10,247,200.00** | **4,307,900.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **10,247,200.00** | **4,307,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **10,247,200.00** | **4,307,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 10,247,200.00 | 4,307,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10,247,200.00 | 4,307,900.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-10,247,200.00** | **-4,307,900.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 929,074,695.17 | 92,789,068.84 | -154,828,226.11 | 00.00 | 867,035,537.90 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **929,074,695.17** | **92,789,068.84** | **-154,828,226.11** | **00.00** | 867,035,537.90 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -1,507,454.30 | 00.00 | -1,507,454.30 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **965,074,695.17** | **294,887,583.03** | **-74,584,244.55** | **00.00** | 1,185,378,033.65 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **965,074,695.17** | **294,887,583.03** | **-74,584,244.55** | **00.00** | 1,185,378,033.65 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **965,074,695.17** | **294,887,583.03** | **-74,584,244.55** | **00.00** | 1,185,378,033.65 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 174,061,350.32 | 00.00 | 174,061,350.32 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **965,074,695.17** | **294,887,583.03** | **99,477,105.77** | **00.00** | 1,359,439,383.97 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 364,855,199.00 | 364,855,199.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 364,855,199.00 | 364,855,199.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 363,905,199.00 | 362,657,946.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 171,213,800.00 | 171,213,800.00 |
| 210101 | Үндсэн цалин | 141,895,000.00 | 141,895,000.00 |
| 210102 | Нэмэгдэл | 29,318,800.00 | 29,318,800.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 23,113,700.00 | 23,113,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,265,300.00 | 16,265,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,712,100.00 | 1,712,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,369,600.00 | 1,369,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 342,400.00 | 342,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,424,300.00 | 3,424,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,271,826.00 | 26,271,826.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,497,642.00 | 3,497,642.00 |
| 210302 | Түлш, халаалт | 21,185,784.00 | 21,185,784.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,588,400.00 | 1,588,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,181,600.00 | 5,954,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,200,000.00 | 1,200,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,114,000.00 | 1,114,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 144,000.00 | 144,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,723,600.00 | 1,496,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,007,773.00 | 2,007,773.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,007,773.00 | 2,007,773.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,254,900.00 | 261,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,254,900.00 | 261,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 129,593,300.00 | 129,566,997.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 127,147,300.00 | 127,120,997.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000.00 | 200,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 800,000.00 | 800,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 78,000.00 | 78,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 177,000.00 | 177,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 181,000.00 | 181,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,010,000.00 | 1,010,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4268300.00 | 4267950.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,235,300.00 | 3,235,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,033,000.00 | 1,032,950.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 950000.00 | 943420.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 950,000.00 | 943,420.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 950,000.00 | 943,420.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 364,855,199.00 | 364,855,199.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 336,575,600.00 | 336,575,600.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 336,575,600.00 | 336,575,600.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 28,279,599.00 | 28,279,599.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 28,279,599.00 | 28,279,599.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 19.00 | 20.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 07.00 | 10.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 11.00 | 09.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **66,755,440.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **66,755,440.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 55,380,320.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,995,100.00 |
| 210602 | Тавилга | 1,430,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,565,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 46,155,220.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 46,155,220.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,230,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,230,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 66,755,440.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 66,755,440.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 00.00 |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 63,755,440.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | 00.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Г.Өлзийбүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Ж.Ням-Осор, аудитор Ш.Нарантуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Гэрэлт хөхийн тэнцвэр Аудит ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь хүүхэд залуучуудын эрх, хөгжил, хамгаалал, оролцоог хангах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл

- Хүүхэд, залуучуудын эрх, хөгжил, хамгааллын үйл ажиллагаа

Тайлант хугацаанд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол улсын хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн А/87 тоот тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлаж, 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажилласан байна.
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх өөрчлөлт;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д” Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана”.(2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн)
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д” Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн баримт болон санхүүгийн тайланг архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол 10-аас доошгүй жил хадгална” (2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)
- Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ны 382 дугаар тогтоолын 5-д “Төрийн захиргааны албан хаагчийн нэмэгдэл хөлс, төрийн үйлчилгээний албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тооцож олгосугай.

## 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Төсвийн шууд захирагч нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 520,412.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 10,408.2 мянган төгрөгөөр тогтоолоо.

## 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 174,345.9 мянган төгрөгөөр буюу 14.7 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| ***Б*** | ***1*** | ***2*** | ***3=2-1*** |
| Мөнгөн хөрөнгө | | | - |
| Авлага | | 11,375.1 | 11,375.1 |
| Урьдчилгаа | | | - |
| Бараа материал | 93,837.1 | 103,975.1 | 10,138.0 |
| Үндсэн хөрөнгө | 1,091,541.0 | 1,244,373.7 | 152,832.7 |
| **Нийт хөрөнгө** | **1,185,378.0** | **1,359,723.9** | **174,345.9** |
| Өр төлбөр | | 284.5 | 284.5 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 965,074.7 | 965,074.7 | - |
| Хуримтлагдсан үр дүн | - 74,584.2 | 99,477.1 | 174,061.4 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 294,887.6 | 294,887.6 | - |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,185,378.0** | **1,359,723.9** | 174,345.9 |

Төсөвт байгууллага нь мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг оны эцэст төсөвт буцаан төвлөрүүлдэг учир мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна. Оны эцэст цалингийн урьдчилгааны үлдэгдэлгүй байна.

Бараа материалын тайлангийн үлдэгдэл 103,975.1 мянган төгрөг болж 10,138.0 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал 3,094.5 мянга, бичиг хэргийн материал 836.2 мянга, аж ахуйн материал 5,278.2 мянга, түлш, шатах тослох материал 248.9 мянга, хүнсний материал 680.2 мянган төгрөгөөр өссөн нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 152,832.7 мянган төгрөгөөр өссөн нь өөрийн хөрөнгөөр 4,307.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч, 260,481.2 мянган төгрөгийн барилга байгууламж, бусад үндсэн хөрөнгө хандиваар ирсэнээс шалтгаалжээ.

Биет бус хөрөнгийн дансанд 2020 оны тайлант хугацаанд ямар нэгэн материаллаг хэмжээний өөрчлөлт гараагүй байна. Мөн 2020 онд Оны эцэст 11,375.1 мянган төгрөгийн авлага шинээр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,359,439.4 мянган төгрөг болж 174,061.4 мянган төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүн өссөнөөс шалтгаалжээ. Энэ нь тайлант оны элэгдлийн зардал болон үндсэн хөрөнгийн данс нэмэгдсэнтэй холбоотой байна.

2020 оны мөнгөн гүйлгээний тайлангаар нийт орлого өмнөх оноос 431,610.6 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар өссөн байна. Нийт зардал өмнөх оноос 18,007.3 мянган төгрөгөөр өссөн байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжүүлэх эх үүсвэрийг 557,036.7 мянга, орон нутгийн төсвөөс санхүүжих 69,340.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 626,376.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 248,965.7 мянган төгрөгөөр бууруулж, 377,411.0 мянган төгрөгөөр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нэг хөтөлбөр, гурван арга хэмжээг санхүүжүүлэхээр 958,226.5 мянган төгрөгийн төсөв улсын төсвөөс баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс санхүүжилтийг бүрэн авч 957,722.3 мянган төгрөгийг зарцуулж 504.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

| № | Зардлын бүлгийн код | Зардлын бүлгийн нэр | 2020 оны батлагдсан төсөв | Үүнээс: 2020 он | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Зарцуулах эрх үүссэн | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү (+,-) |
| **Урсгал зардлын тооцоо** | | | | | | |
| 1 | 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал | 171,213,800.00 | 171,213,800.00 | 171,213,800.00 | - |
| 2 | 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 23,113,700.00 | 23,113,700.00 | 23,113,700.00 | - |
| 3 | 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 26,271,826.00 | 26,271,826.00 | 26,271,826.00 | - |
| 4 | 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,181,600.00 | 6,181,600.00 | 5,954,000.00 | 227,600.00 |
| 5 | 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,007,773.00 | 2,007,773.00 | 2,007,773.00 | - |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6 | 2107 | Томилолт зочны зардал | 1,254,900.00 | 1,254,900.00 | 261,900.00 | 993,000.00 |
| 7 | 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 129,593,300.00 | 129,593,300.00 | 129,566,997.00 | 26,303.00 |
| 8 | 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,268,300.00 | 4,268,300.00 | 4,267,950.00 | 350.00 |
| 9 | 2131 | Гадаад урсгал шилжүүлэг | | | | - |
| 10 | 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 950,000.00 | 950,000.00 | 943,420.00 | 6,580.00 |
| **Урсгал зардлын дүн** | | | **364,855,199.0** | **364,855,199.0** | **363,601,366.0** | **1,253,833.0** |

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 3,000.0 мянга, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 63,755.4 мянга нийт 66,755.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тавилга эд хогшил худалдан авах зардалд 1,430.0 мянга, урсгал засварын зардалд 1,565.1 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 46,155.2, бараа үйлчилгээний бусад зардалд 6,230.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны shilendans.gov.mn цахим хуудсанд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлбэл зохих 2020 оны 149 мэдээллийг бүрэн мэдээлж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг ил тодын самбарт нээлттэйгээр бүрэн байршуулсан байна.

Тус онд шилэн дансанд мэдээлэх 149 мэдээллээс 149 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар Сангийн сайдын 2014 оны 55 тоот тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал батлах тухай” журмыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлэн ажилласан байна.

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 81,153.5 мянган төгрөгийн зөрчилд 70,356.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, УСНББОУС, НББББББ-ийн дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөх зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа**

Аудитаар залруулсан алдаа гараагүй болно.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар зөвлөмж өгөхөөс бусад алдаа, зөрчил илрээгүй.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

## 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дэлхий дахинд дэгдэж буй Ковид-19 халдварын нөхцөл байдлаас шалтгаалан 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шалгагдагч байгууллагын эргэлтийн болон үндсэн хөрөнгөнд биет шалгалт хийгээгүй ба тухайн байгууллагын аудитад өгсөн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас түүвэрлэн шалгахад элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч нөхөн сэргээж цаашид ашиглах шаардлагатай хөрөнгүүд байна.

Мөн УСНББОУС-ын дагуу тооцоолсон цалингаар цалингийн өглөг үүсгээгүй, цалингийн зардалд шууд бичилт хийгдсэн байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 4.1 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

4.1.1 <u>Илрүүлэлт:</u>

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтыг аваагүй /цахим Е баримтын бүрдлийг ханган ажиллаагүй/ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2."бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй". заалтуудыг зөрчсөн.

<u>4.1.2 Эрсдэл:</u>

Хууль тогтоомжууд зөрчигдөж, татварыг нуун дарагдуулах боломжийг бусдад олгоно, татварын орлого дутуу бүрдэх;

<u>4.1.3 Өгсөн зөвлөмж:</u>

Худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримттай бараа, үйлчилгээг авч байх, цаг тухайд цахим Е-баримтыг хангуулан бүртгэлд тусгах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

<u>4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:</u>

ТШЗ-ын зүгээс хойшид анхаарч, алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Аудитын код: |
|---|---|---|
| 2021.02.25 | ***Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | ДГА-2021/140/СТА-ТШЗ |

| Шалгагдагч байгууллагын нэр: | | Мянган төгрөг |
|---|---|---|
| *Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар* | | |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| 1 | Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтыг аваагүй /цахим Е баримтын бүрдлийг ханган ажиллаагүй/. | | Зөвлөмж хүргүүлэх | Дарга, Нягтлан бодогч | Г.Өлзийбүрэн, Д.Отгонбулаг |
| НИЙТ ДҮН | | | | | |